ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДОА-2026/007/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2026 он | Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал,<br>Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 51-261663, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Ухаанбилэг<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................ 2-3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................................................4-9

3. Аудитын илрүүлэлт ....................................................................................................9

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..........................................................10-14

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 06/782
танай ____________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5 сарын 30-ны өдрийн 05/05 тогтоолоор “Чойбалсан хотын соёл, амралтын хүрээлэн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”-ыг шинээр байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу харьяа

Z:\Yawsan_Bichig\2026\0316 SAG-67.Docx

байгууллагуудын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй нь төрийн албыг цомхон бүтээмжтэй ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах бодлогын хэрэгжилтэд нөлөөлөх эрсдэлийг бий болгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
АТА16087
9025081411

Z:\Yawsan_Bichig\2026\0316 SAG-67.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган.төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 9,038,596.5 | 8,465,277.8 |
| 31 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, | 6,640,849.9 | 5,990,970.1 |
| 33 | 1.1.3 АВЛАГА | | 1,045,053.2 | 1,002,629.3 |
| 35 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | | 1,292,993.4 | 1,413,378.5 |
| 36 | 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | | 59,700.0 | 58,300.0 |
| 2 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 38,469,944.0 | 55,755,494.1 |
| 39 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 38,469,944.0 | 55,755,494.1 |
| 39200 | 1.2.2.02 Биет хөрөнгө | | 33,468,842.9 | 50,482,494.0 |
| 39300 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | | 5,001,101.0 | 5,273,000.1 |
| 3 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 47,508,540.5 | 64,220,771.9 |
| 4 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 18,562.4 | 744,871.1 |
| 41 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 18,562.4 | 744,871.1 |
| 5 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 47,489,978.1 | 63,475,900.8 |
| 51 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 47,489,978.1 | 63,475,900.8 |
| 51100 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 10,516,460.1 | 10,516,460.1 |
| 511002 | 2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | 10,516,460.1 | 10,516,460.1 |
| 51200 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 36,419,384.8 | 52,369,236.4 |
| 51210 | 2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн | | 24,456,648.7 | 36,849,292.0 |
| 51220 | 2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн | | 11,962,736.1 | 15,519,944.4 |
| 51300 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 554,133.2 | 590,204.3 |
| 6 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 47,508,540.5 | 64,220,771.9 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган.төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 76,459,036.1 | 102,585,639.3 |
| 11 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 27,339,005.1 | 31,704,535.7 |
| 110 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 22,556,330.9 | 24,593,126.6 |
| 113 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 1,175,471.7 | 1,357,946.5 |
| 118 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 3,607,202.5 | 5,753,462.6 |
| 12 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 16,819,652.4 | 70,881,103.7 |
| 120 | 1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | | 16,813,652.4 | 29,324,164.6 |
| 122 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 6,000.0 | 38,733,743.3 |
| 1221 | 1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/ | | - | 38,726,243.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 122002 | 1.1.1.04.3.02 Хандив тусламж /гадаад/ | | 6,000.0 | 7,500.0 |
| 123 | 1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | - | 2,823,195.8 |
| 123002 | 1.1.1.04.4.02 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого \УТ-ОН\ | | - | 2,823,195.8 |
| 13 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 32,300,378.6 | - |
| II | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 57,382,865.2 | 79,247,921.2 |
| 21 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 57,382,865.2 | 79,247,921.2 |
| 210 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 17,246,903.1 | 25,024,005.0 |
| 2101 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,911,204.4 | 5,642,943.7 |
| 2102 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 471,341.0 | 317,898.6 |
| 2103 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,720,761.9 | 2,059,615.3 |
| 2104 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 589,421.3 | 708,415.1 |
| 2105 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 39,095.5 | 82,059.2 |
| 2106 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 589,462.4 | 978,071.8 |
| 2107 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 3,720.0 | 12,580.0 |
| 2108 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,504,449.3 | 2,966,463.8 |
| 210801 | 1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,482,506.8 | 2,923,010.7 |
| 2109 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 8,417,447.3 | 12,255,957.5 |
| 213 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 40,135,962.1 | 54,223,916.2 |
| III | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 19,076,170.9 | 23,337,718.2 |
| V | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 7,113,434.8 | 7,817,773.8 |
| 225001 | 1.2.2.01 Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 278,896.5 | 544,010.8 |
| 225010 | 1.2.2.10 Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | | 6,834,538.3 | 7,223,317.7 |
| 225011 | 1.2.2.11 Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | | - | 50,445.3 |
| VII | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | (7,113,434.8) | (7,817,773.8) |
| VI | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 11,962,736.1 | 15,519,944.4 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/

/мянган.төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 35,527,242.0 | | 35,527,242.0 |
| 2 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 35,527,242.0 | | 35,527,242.0 |
| 3 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 11,962,736.1 | | 11,962,736.1 |
| 4 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 47,489,978.1 | | 47,489,978.1 |
| 5 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 47,489,978.1 | | 47,489,978.1 |
| 6 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 404,727.5 | | 404,727.5 |
| 7 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 47,894,705.5 | | 47,894,705.5 |
| 8 | 1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 61,250.9 | | 61,250.9 |
| 9 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 15,519,944.4 | | 15,519,944.4 |
| 10 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 63,475,900.8 | | 63,475,900.8 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган.төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | | 63,222,991.4 | 79,325,032.6 |
| 11 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 27,339,005.1 | 31,704,535.7 |
| 110 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 22,556,330.9 | 24,593,126.6 |
| 113 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 1,175,471.7 | 1,357,946.5 |
| 118 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 3,607,202.5 | 5,753,462.6 |
| 12 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 3,744,367.6 | 47,620,497.0 |
| 120 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | | 3,738,367.6 | 9,883,813.6 |
| 122 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 6,000.0 | 34,913,487.5 |
| 123 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | - | 2,823,195.8 |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 32,139,618.7 | - |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 53,059,380.3 | 73,104,723.1 |
| 21 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 53,059,380.3 | 73,104,723.1 |
| 210 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 12,922,072.9 | 18,906,645.3 |
| 2101 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,911,337.4 | 5,648,435.8 |
| 2102 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 471,341.0 | 317,898.6 |
| 2103 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,751,886.8 | 2,105,045.1 |
| 2104 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 566,654.0 | 661,535.0 |
| 2105 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 25,358.3 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2106 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 294,395.1 | 408,031.9 |
| 2107 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 3,720.0 | 10,580.0 |
| 2108 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,509,776.8 | 7,459,684.3 |
| 2109 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 4,387,603.6 | 2,295,434.7 |
| 213 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 40,137,307.4 | 54,198,077.8 |
| III | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 10,163,611.1 | 6,220,309.5 |
| V | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | | 7,177,153.2 | 6,495,189.4 |
| 22 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 7,177,153.2 | 6,495,189.4 |
| 2200 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | | 7,177,153.2 | 6,495,189.4 |
| VI | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | (7,177,153.2) | (6,495,189.4) |
| 23 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 40,000.0 | 375,000.0 |
| VII | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | (40,000.0) | (375,000.0) |
| VIII | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | 2,946,457.9 | (649,879.8) |
| 101 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 3,694,392.0 | 6,640,849.9 |
| 20 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 6,640,849.9 | 5,990,970.1 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган.төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 71,014,960.4 | 69,142,285.7 | 1,872,674.7 | 97.4 |
| 11 | 3.1.01.1.1 Татварын орлого | 31,125,328.6 | 31,704,535.7 | (579,207.1) | 101.9 |
| 110 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 24,853,200.0 | 24,593,126.6 | 260,073.4 | 99.0 |
| 113 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 1,273,040.0 | 1,357,946.5 | (84,906.5) | 106.7 |
| 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 4,999,088.6 | 5,753,462.6 | (754,374.0) | 115.1 |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 39,889,631.8 | 37,437,750.1 | 2,451,881.7 | 93.9 |
| 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 1,337,700.0 | 931,131.8 | 406,568.2 | 69.6 |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 35,656,346.4 | 33,683,422.5 | 1,972,923.9 | 94.5 |
| 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 2,895,585.4 | 2,823,195.8 | 72,389.6 | 97.5 |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 39,284,447.8 | 70,039,945.7 | (30,755,497.9) | 178.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 30,901,886.1 | 63,176,424.3 | (32,274,538.2) | 204.4 |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 10,492,423.5 | 9,997,076.4 | 495,347.1 | 95.3 |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,573,441.4 | 2,541,178.2 | 32,263.2 | 98.7 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 317,899.1 | 317,898.6 | 0.5 | 100.0 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,908,063.4 | 1,600,953.5 | 307,109.9 | 83.9 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 60,160.4 | 49,926.8 | 10,233.6 | 83.0 |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 400,575.2 | 396,631.9 | 3,943.3 | 99.0 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 13,368.7 | 10,580.0 | 2,788.7 | 79.1 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,838,668.5 | 2,836,798.6 | 1,869.9 | 99.9 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 2,380,246.8 | 2,243,108.9 | 137,137.9 | 94.2 |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,409,462.6 | 53,179,347.9 | (32,769,885.3) | 260.6 |
| 2131 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 20,361,955.1 | 53,137,877.6 | (32,775,922.5) | 261.0 |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 47,507.5 | 41,470.3 | 6,037.2 | 87.3 |
| 22 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,882,561.7 | 6,488,521.4 | 1,394,040.3 | 82.3 |
| 23 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 500,000.0 | 375,000.0 | 125,000.0 | 75.0 |
| 8 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 31,730,512.6 | (897,659.9) | 32,628,172.5 | (2.8) |
| 9 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (31,730,512.6) | 897,659.9 | (32,628,172.5) | (2.8) |
| 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (31,730,512.6) | 897,659.9 | (32,628,172.5) | (2.8) |
| 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 6,537,889.9 | (6,537,889.9) | |
| 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 5,640,230.0 | (5,640,230.0) | |
| 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 191.0 | 191.0 | - | 100.0 |
| 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 13.0 | 13.0 | - | 100.0 |
| 610001 | 6.1.01 Төсвийн байгууллага | 13.0 | 13.0 | - | 100.0 |
| 62 | 6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО | 89.0 | 89.0 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | 6.2.01 Удирдах ажилтан | 15.0 | 15.0 | - | 100.0 |
| 620002 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 54.0 | 54.0 | - | 100.0 |
| 620003 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 16.0 | 16.0 | - | 100.0 |
| 620004 | 6.2.04 Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |
| 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 89.0 | 89.0 | - | 100.0 |
| 650001 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 51.0 | 51.0 | - | 100.0 |
| 650009 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16.0 | 16.0 | - | 100.0 |
| 650010 | 6.5.10 Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |
| 650011 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 18.0 | 18.0 | - | 100.0 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган.төгрөгөөр/

| Дансны код | Тайлангийн үзүүлэлт | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 215,665.1 |
| 12 | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 215,665.1 |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 215,665.1 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 215,665.1 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 215,665.1 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 211,335.1 |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 144,000.0 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 3,609.4 |
| 2106 | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 11,400.0 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 52,325.8 |
| 213 | 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,330.0 |
| 2132 | 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 4,330.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71.7 сая төгрөгийн 2 зөрчил[1] илэрсэнд албан шаардлага өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 208.7 сая төгрөг, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 71.7 сая төгрөгийн зөрчил, нийт 280.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

**3.1.1.** Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06/07 дугаар "Сумын 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор 2025 оны анхны батлагдсан төсөвт тусгагдаагүй 71.7 сая төгрөгийн 4 арга хэмжээг шинээр нэмж тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-т "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**3.1.2**. Хэрлэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага болох Засаг даргын тамгын газар, Хоршоо хөгжүүлэх сан аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан, Иргэдийн төлөөлөгчдийн хурал түүвэрт хамрагдсан, Орон нутгийн хөгжлийн сан болон Хэрлэн тохижилт, Чойбалсан хөгжил Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд өөрчлөлтгүй дүгнэлт авсан байна. Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,590.2 сая төгрөгийн 34 санхүү, нийцлийн зөрчил илэрсэнд 40.7 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 410.9 сая төгрөгийн 15 албан шаардлага, 1,138.5 сая төгрөгийн 11 зөвлөмж өгсөн.

Шийдвэрлэсэн нь: Нийт зөрчлийг 30.0 хувиар бууруулах арга хэмжээ авсан байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Харьяа байгууллагуудын нэр | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Гүйцэтгэсэн горим сорилын үр дүн (нөхцөл байдал) | Мөнгөн дүн | Залруулга хийсэн | | | | Залруулга хийхэд үндэслэл болсон хууль тогтоомж, стандартын нэр, заалт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Санхүүгийн тайлан | Тодруулга | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | | |
| Хэрлэн сумын ЗДТГ | Тодруулга | Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн | 50,400.0 | 50,400.0 | 50,400.0 | - | - | НББ-ийн тухай хуулийн 20.2.10 | - |
| | Тодруулга | Замын зураг төсвийг үндсэн хөрөнгөнд бүртгэж элэгдэл тооцсон | 134,000.0 | 134,000.0 | 134,000.0 | - | - | НББ-ийн тухай хуулийн 20.2.10 | - |
| **ТШЗ-ийн дүн** | | | **184,400.0** | **184,400** | **184,400** | **-** | **-** | **-** | **-** |
| Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ | Ажил гүйлгээний анги | Байгууллагын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. | 37,597.7 | 37,597.7 | 37,597.7 | | | НББ-ийн тухай хуулийн 20.2.10 | |
| Хэрлэн тохижилт | Ажил гүйлгээний анги | Ажлын хувцас худалдан | 30,360.0 | 30,360.0 | 30,360.0 | | | НББ-ийн тухай | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээ ОНӨААТҮГ | | авахдаа бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна | | | | | | хуулийн 20.2.10 | |
| Хэрлэн тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ | Тодруулга | Худалдан авсан контейнерыг бараа материалаар бүртгэсэн байна | 12,000.0 | 12,000.0 | 12,000.0 | | | НББ-ийн тухай хуулийн 20.2.10 | |
| Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ | Тодруулга | Ажлын нормын хувцсыг шууд зардалд бүртгэсний г орлого болгож залруулсан | 5,188.4 | 5,188.4 | 5,188.4 | | | НББ-ийн тухай хуулийн 20.2.10 | |
| ОНӨААТҮГ-ын дүн | | | 85,146.1 | 85,146.1 | 85,146.1 | | | | |
| **Нийт дүн** | | | **269,591.3** | **269,591.3** | **269,591.3** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хэрлэн сумын Засаг дарга | Тодотголоор төсөвт тусгагдаагүй байсан 4 ТАХ-г нэмсэн | 1 | - | - | - | 1 | 71,700.0 | - | - |
| Хэрлэн сумын Засаг дарга | Харьяа байгууллагуудын нийт зөрчлийг 30 хувиар бууруулах | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **ТТЗ-ийн дүн** | | **2** | **-** | **-** | **-** | **2** | **71,700.0** | **-** | **-** |
| Хэрлэн сумын ИТХ | Мэргэжлийн үнэмлэхгүй албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон | 1 | 1,360.1 | 1 | 1,360.1 | - | - | - | - |
| | Шууд худалдан авалт хийсэн | 1 | 14,359.1 | - | - | 1 | 14,359.1 | - | - |
| | Гадаад томилолтыг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргасан | 1 | 3,940.0 | - | - | 1 | 3,940.00 | - | - |
| Хэрлэн сумын ЗДТГ | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дууны клип, зар сурталчилгааны зардал гаргасан | **1** | 6,000.0 | **1** | 6,000.0 | | | | |
| | Төсвийн хөрөнгөөр уралдаан тэмцээн зохион | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулахдаа тээврийн хэрэгсэл худалдан авсан | | | | | | | | |
| | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, тэмцээн уралдааны шагнал, хөдөө орон нутагт ажилласан тэтгэмжээс ХХОАТ суутган тооцоогүй | 1 | 25,575.0 | 1 | 25,575.0 | - | - | - | - |
| | Согтууруулах ундаа худалдан авсан | 1 | 359,7 | 1 | 359,7 | | | | |
| | Спортын хувцас худалдан авсан | 1 | 18,000.0 | | | 1 | 18,000.0 | | |
| | Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгосон | 1 | 8.976.0 | | | 1 | 8,976.0 | | |
| | Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг хэтрүүлэн зарцуулсан | 1 | 2,134.1 | | | 1 | 2,134.1 | | |
| | Байгууллагын нярвын харилцах дансаар бусдад өгөх тусламж, арга хэмжээ зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн | 1 | 79,102.3 | | | | | 1 | 79,102.3 |
| Хэрлэн сумын Хоршоо хөгжүүлэх сан | Хоршоо хөгжүүлэх сангаас 2021-2025 онд зээл авсан 18 иргэн, аж ахуйн нэгжид хугацаа хэтрүүлсэн зээлийн үлдэгдэлд алданги тооцоогүй байна | **1** | 2,342.7 | | | **1** | 2,342.7 | | |
| | Авлага барагдуулах албан шаардлага хэрэгжүүлээгүй | 1 | **15,273.0** | | | 1 | **15,273.0** | | |
| **ТШЗ-ийн дүн** | | **13** | **187,422.0** | **4** | **33,294.7** | **8** | **75,024.9** | **1** | **79,102.3** |
| Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ | Гадаад томилолтын хуудасгүй зардал гаргасан | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | | | | |
| Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ | Батлагдсан төсвөөс чихэр, хүүхдийн бэлэг, хоолны материал авсан | 1 | 3,229.8 | 1 | 3,229.8 | | | | |
| | Хувийн автомашиндаа | 1 | 2,192.8 | 1 | 2,192.8 | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шатахууны зардал гаргасан | | | | | | | | |
| | Он дамжсан авлага тооцоо нийлж баталгаажуулаагүй | 1 | 12,708.0 | | | 1 | 12,708.0 | | |
| | Төсөв батлагдаагүй байхад томилолтын зардал гаргасан | 1 | 1,200.0 | | | 1 | 1,200.0 | | |
| **ОНӨҮГ-ын дүн** | | **5** | **21,330.6** | **3** | **7,422.6** | **2** | **13,908.0** | **-** | **-** |
| **Нийт дүн** | | **18** | **208,752.6** | **7** | **40,717.3** | **10** | **88,932.9** | **1** | **79,102.3** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Байгууллагын нэр | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хэрлэн сумын Засаг дарга | Харьяа байгууллагуудын зөрчлийг бууруулах | 1 | 0 | - | - | 1 | 0 | - | - |
| **ТТЗ-ийн дүн** | | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| Хэрлэн сумын ИТХ | Шилэн дансны цахим сайтад 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | | | | | | 1 | |
| Хэрлэн сумын ЗДТГ | Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл хүргэх мэдээллийн сайт нь идэвхгүй байна | 1 | 7,000.0 | | | 1 | 7,000.0 | | |
| | Төсвийн тодотголыг спортын тэмцээн уралдаан зохион байгуулах дэмжлэгт зориулсан | 1 | 60,000.0 | | | 1 | 60,000.0 | | |
| | 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 1 мэдээлэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан,байгууллагын батлагдсан төсөв 2 мэдээллийг хоцорч мэдээлсэн | 1 | 13,570.0 | | | | | 1 | 13,570.0 |
| | УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 48 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сан | Хэрлэн сумын 2 дугаар багт хийгдсэн 27.9 сая төгрөгийн тоглоомын талбай барих ажил нь газрын маргаантай асуудлаас болж тухайн ажлыг комисс хүлээн аваагүй байна | 1 | 27,879.8 | | | | | 1 | 27,879.8 |
| | Хэрлэн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын ААН-д өгөх 734.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна | 1 | 734,796.3 | | | | | 1 | 734,796.3 |
| Хэрлэн сумын Хоршоо хөгжүүлэх сан | Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2020 онд зээл авсан 13 иргэн, аж ахуйн нэгжид Шүүхээс зээлийг эргэн төлүүлэх шийдвэр гарсан ч хэрэгжээгүй байна. | 1 | 195,279.1 | | | | | 1 | 195,279.1 |
| | Хоршоо хөгжүүлэх сангаас 2021 онд зээл авсан 4 иргэн, аж ахуйн нэгжийг авсан зээлээ хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулаагүй | 1 | 66,687.4 | | | | | 1 | 66,687.4 |
| | Чанаргүй зээлийн зохистой харьцааг хангаж ажиллаагүй буюу нийт хөрөнгийн 36.3 хувийг чанаргүй зээлийн авлага эзэлж байна | 1 | - | | | | | 1 | 0 |
| **ТШЗ дүн** | | **10** | **1,105.2** | **-** | **-** | **2** | **67,000.0** | **8** | **1,038.2** |
| Хэрлэн тохижилт ОНӨААТҮГ | Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй | 1 | 84,253.0 | | | 1 | 84,253 | | |
| Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ | Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш гүйлгээг мэдээлээгүй | 1 | 46,569.4 | | | 1 | 46,569.4 | | |
| | Худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд худалдан авалт хийсэн | 1 | 124,240.2 | | | 1 | 124,240.2 | | |
| | Санхүүгийн тайланг төсөвт байгууллагын маягтаар бэлтгэсэн | 1 | | | | | | 1 | |
| | Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн, санхүүгийн тайлан дахь өмчийн дүнгээс зөрүүтэй байна | 1 | 21,214.8 | | | | | 1 | 21,214.8 |
| **ОНӨААТҮГ-ын дүн** | | **5** | **192,108.6** | | | **3** | **170,893.5** | **2** | **21,214.8** |